


“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ын
даргын 2023 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн
53 тоот албан бичгийн хавсралт



Бэлчээрийн менежмент төслийн нэгж ОНӨТҮГ-ын 2022 оны
Санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмжийн биелэлт

№	Зөвлөмж	Биелэлт	Дуусах хугацаа
1	Асуудал-1 : Зардлын данстай холбоотой асуудал Энэ оны эхний 6 сарын байдлаар 21 аж ахуйн нэгж байгууллагаас 35,199.45 мянган төгрөгийн худалдан авалт хийгдсэн бөгөөд үүнээс 31,826.85 мянган төгрөгийн И баримт шивэгдсэн ба 3 байгууллагын 3,372.6 мянган төгрөгийн худалдан авалтын И баримт дутуу шивэгдсэн байна. Зөвлөмж-1 Хойшдоо И-баримтын бүрдэл хангаагүй гүйлгээг бүртгэхгүй байх, бүртгэлд тавих хяналтыг сайжруулах	Байгууллагын худалдан авсан бараа, үйлчилгээний зардлын баримтын анхан шатны материалуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6 заалт, НӨАТ-ын тухай хуулийн 17.6 заалт, Сангийн сайдын 2018 оны 347 дугаар тушаалын хавсралттай нийцүүлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон И-баримт системд бүртгэлжүүлэн ажиллаж байна. Тус асуудлыг шийдвэрлүүлсэн бөгөөд сар дамнан шивэлт хийлгэхгүй тал дээр анхаарч ажиллаж байна.	2023.03.31
2	Асуудал-2 УСНББОУС12 бараа материал, Биологийн хөрөнгөнөөс хүлээн авсан ХАА-н бүтээгдэхүүний өртөг, зүйл 29: УСНББОУС 27 ХАА, 13-р зүйл хүлээн зөвшөөрөл ба хэмжилт: Дуусаагүй үйлдвэрлэл дансанд газар тариалан, мал аж ахуйтай холбоотой гарсан шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг тусгахгүйгээр үйл ажиллагааны зардлаар бүртгэж байна. Зөвлөмж-2 Дуусаагүй үйлдвэрлэл дансанд үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг тооцон бүртгэх	Аудитын зөвлөмжийн хүрээнд Дуусаагүй үйлдвэрлэл дансны бүртгэлийг хийхэд байгууллагын статустай уялдуулан мал амьтад, малын тэжээлийн өртөг зэрэг давхардан зардал болон орж ирэн үнийн хөөрөгдөл гарч байгаа асуудлыг Үйлдвэрлэлийн процесс хөтлөх боломж, шаардлагадаа нийцүүлж шинэчлэн өөрчлөх. Мөн дуусаагүй үйлдвэрлэлд ашиглагдах дансдыг НБББББ-т тусгасны дагуу өртгийн төв бүрээр нээж, шууд материал, хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын дансдыг бүртгэх тал дээр анхаарч ажиллах болно.	2023.03.31

Тайлан гаргасан:
Нягтлан бодогч:

Ц.Мөнхдөл